



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 4/30

Улаанбаатар хот

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал
ба тодорхойлолт 08-д нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан үндэсний индекс/код дахь 3351 нэгж бүлэгт "3351-15 Хилчин", 5411 нэгж бүлэгт "5411-18 Объектын/үйлдвэрийн гал сөнөөгч", "5411-19 Гал унтраах аврах, үндсэн тусгай туслах авто машины жолооч/шатны техникч", 5412 нэгж бүлэгт "5412-16 Олон нийтийн цагдаа", 5414 нэгж бүлэгт "5414-17 Хамгаалалтын ажилтан, дотоодын цэргийн" гэж тус тус шинээр нэмсүгэй.


2. Шинээр нэмсэн ажил, мэргэжлийн мэдээллийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Хууль сахиулах байгууллагууд энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан ажил, мэргэжлийн ангиллыг үндэслэн ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолт боловсруулах, хөдөлмөрийн норм, норматив тогтоохдоо мөрдөхийг зөвлөсүгэй.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 21 дугаар сарын 09-ны өдрийн
1/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН МЭДЭЭЛЭЛ

3351 Хил, гаалийн байцаагч

3351-15 Хилчин

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Border guard

Ажлын байрны тодорхойлолт: Улсын хилийн хариуцсан хэсэгт хил хамгаалалтыг зохион байгуулах, хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн харуул, манааг удирдах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, албаны бэлэн байдлыг хангах, инженер-техникийн төхөөрөмж, дохиоллын болон холбооны хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ашиглах болон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуулиар олгосон бусад үүргийг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Гэрээт-хилчин
- Хилчин-шалгагч
- Хилчин-офицер
- Хилчин-ахлагч
- Хилчин-холбоочин
- Хилчин-оператор
- Хилчин-эд хариуцагч
- Хилчин-харуулын дарга

5411 Аврагч

5411-18 Объектын /үйлдвэрийн гал сөнөөгч

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Industrial firefighter

Ажлын байрны тодорхойлолт: Объектын/үйлдвэрийн гал сөнөөгч нь тухайн албан байгууллагад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах, гал түймрийн аюулын үед хүний амь насыг аврах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх,

иргэдийн болон аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгийг авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд оролцох үүргийг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Үйлдвэрийн гал сөнөөгч
- Объектын гал сөнөөгч

5411-19 Гал унтраах аврах, үндсэн тусгай туслах авто машины жолооч /шатны техникч /

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Operator of turntable ladder

Ажлын байрны тодорхойлолт: Гал унтраах авто машины жолооч нь гал унтраах тусгай зориулалтын үндсэн, туслах автомашины техникийн үйлчилгээ, өдөр тутмын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүний амь, нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг аврахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Гал унтраах аврах, үндсэн тусгай туслах авто машины жолооч
- Гал унтраах үндсэн болон туслах албаны машины жолооч

5412 Цагдаагийн ажилтан

5412-16 Олон нийтийн цагдаа

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Community Police

Ажлын байрны тодорхойлолт: Олон нийтийн цагдаа нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцох, гэмт хэрэг, зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах, томилогдсон эргүүлийн чиглэлд нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг биечлэн гүйцэтгэх, шаардлагатай хүний бичиг баримтыг шалгаж, оршин суугаа газрын хаягийг тогтоох, хэв журам сахих талаар иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх, хуульд заасан бол зөрчил үйлдсэн этгээдэд торгох шийтгэл оногдуулах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах, нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох, өгөгдсөн үүргийн дагуу хэв журмын хамгаалалтын чиг үүрэг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Цагдаа

- Эргүүлийн цагдаа
- Теле-камерын жижүүрийн цагдаа
- Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа
- Баг, хороо хариуцсан цагдаа
- Хамгаалалтын цагдаа

5414 Хамгаалалтын албаны ажилтан

5414-17 Хамгаалалтын ажилтан, дотоодын цэргийн

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Security officer of internal troops

Ажлын байрны тодорхойлолт: Улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч ачаа тээшийг харгалзан хүргэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Дотоодын цэргийн хамгаалалтын офицер
- Дотоодын цэргийн теле хяналтын ажилтан